

Энэхүү гэрээ нь Merlin.net™ Өвчтөний тусламж, үйлчилгээний сүлжээтэй холбоотойгоор үзүүлэх үйлчилгээнд (доор тодорхойлсон) хамаарна.

ЧУХАЛ– Цааш үргэлжлүүлэхийн өмнө дараах Гэрээг болон түүнд дурдагдсан баримтуудыг анхааралтай уншина уу. Энэ бол та, бидний хооронд байгуулсан хууль ёсны баримт бичиг юм (хоёр нэр томъёог доор тодорхойлсон болно). Үйлчилгээг (доор тодорхойлсон) ашиглахын өмнө, тээнэхүү Гэрээг анхааралтай унших шаардлагатай, учир нь уг Гэрээ нь Үйлчилгээг ашиглахтай холбоотой харилцааг зохицуулна.

Та тус Үйлчилгээг ашиглаж байгаа нь энэхүү Гэрээг хүлээн зөвшөөрсний илэрхийлэл бөгөөд уг Гэрээг дагаж мөрдөх нөхцөлтэйгөөр хэрэгжинэ. "зөвшөөрөх" товчийг дарснаар та Merlin.net-г ашиглахдаа энэхүү Гэрээг дагаж мөрдөхийг зөвшөөрч байна. Хэрэв та эсвэл таны өмнөөс Merlin.net-г ашиглаж байгаа хүн энэхүү Гэрээг зөвшөөрөхгүй бол зөвшөөрөх дээр дарахгүй байж, Merlin.net-г ашиглахгүй байна уу.

Энэхүү Гэрээг хүлээн зөвшөөрч, Merlin.net-г ашигласнаар та өөрийн нэрийн өмнөөс эсвэл хууль ёсоор үүрэг хүлээлгэх эрх бүхий өөр нэгний нэрийн өмнөөс энэхүү Гэрээг хүлээн зөвшөөрч байгаагаа баталгаажуулж байна. Та Merlin.net системд нэвтэрч ашиглаж буй хүн бөгөөд өөрийн холбоотой, ажил эрхэлдэг, эсвэл гэрээгээр ажиллаж буй корпорац, түншлэл, эмнэлэг, үндэсний эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага, эсвэл бусад хуулийн этгээд ("Клиник")-ийн нэрийн өмнөөс эсвэл түүний ашиг тусын тулд үйл ажиллагаа явуулж байгаа бол энэхүү Гэрээг өөрийн болон тухайн Клиникийн нэрийн өмнөөс хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд та уг Клиникийг энэхүү Гэрээгээр хууль ёсоор үүрэг хүлээх эрх бүхий гэдгээ батлан мэдэгдэж байна.

Таны эсвэл таны нэрийн өмнөөс гаргасан аливаа худалдан авах захиалга эсвэл бусад баримт бичигт энэхүү Гэрээнд нэмэлт, зөрчилтэй нөхцөл, санааг агуулсан эсвэл уг Гэрээг солих, татгалзах, өөрчлөх, эсвэл эсрэг санал болгох зорилготой аливаа нөхцөлүүдээс шууд татгалзаж, хүчин төгөлдөр бус гэж тооцно.

"Үүнд", "хамаарах", "ялангуяа", "жишээ нь" зэрэг аливаа нэр томъёо эсвэл үүнтэй төстэй үг хэллэгийг дүрслэн тайлбарлах утгатай гэж үзэх ба холбогдох ерөнхий үг хэллэгийн нийтлэг шинжийг хязгаарлахгүй. Тус Гэрээний гарчгууд нь зөвхөн танд уншихад хялбар байхаар зориулагдсан бөгөөд хэсэг тус бүрийг хязгаарлах, тодорхойлох, эсвэл бүрэн тайлбарлахгүй.

1. **Бидний тухай мэдээлэл:** Merlin.net нь Абботт ажиллуулдаг вебсайт юм.
2. **Гол нэр томъёо:** Энэхүү Гэрээнд дурдагдах дараах нэр томъёонуудыг дараах утгаар ойлгоно:

Администратор. Merlin.net системийн администратор нь Клиникээс клиникийн ID-г үүсгэх, удирдах, хадгалахад зориулагдсан администраторын ID-г өгдөг.

Гэрээ. Эдгээр Үйлчилгээний нөхцөл болон үүнд дурдсан баримт бичгүүд, мөн www.merlin.net вебсайтад нийтлэгдсэн шинэчлэлтүүд эсвэл бидний өгч болох бусад ийм URL хаяг орно.

Командууд. Таны Үйлчилгээнд шууд оруулсан эсхүл өөрийн өмнөөс биднээр дамжуулан оруулахыг даалгасан команд, параметрууд нь танд зарим Өвчтөний Төхөөрөмжүүдийг хянах болон/эсвэл удирдахад туслах зорилгоор Мониторинг дамжуулдаг. Командууд нь Өгөгдөл биш юм.

Өгөгдөл Хамгаалах Хууль. Хувийн мэдээллийн нууцлал, нууцлагдмал байдал, аюулгүй байдал, бүрэн бүтэн байдал болон хамгаалалттай холбоотой бүх холбогдох хууль, журам, заавар, засгийн газрын шаардлагууд, тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулах буюу өөрчилсөн, холбогдох үндэсний хэрэгжүүлэх хууль тогтоомж.

Өгөгдөл. Төхөөрөмжөөс Мониторинг дамжуулан цуглуулсан Өвчтөний өгөгдөл эсвэл мэдээлэл, мөн Үйлчилгээгээр дамжуулан таны оруулсан өгөгдөл.

Төхөөрөмж. Биднээс эсвэл манай салбар, харьяа компаниудаас авсан Merlin.net™ Өвчтөний тусламж, үйлчилгээний сүлжээ (PCN)-тэй нийцтэй аливаа суулгасан зүрхний төхөөрөмж.

Байршлууд. Таны тухайн Үйлчилгээг хүлээн авч байгаа эсвэл тухайн Үйлчилгээний үйл ажиллагааг явуулж байгаа аливаа газар. Жишээлбэл "таны Байршлууд" гэдэгт Өвчтөнүүд

үйлчлүүлдэг эмнэлгийн газруудыг багтаана. "Бидний Байршлууд" гэдэгт манай барилга байгууламж эсвэл Үйлчилгээ явуулж буй бусад газар хамаарна.

Merlin.net-ийн Нууцлалын Бодлого. Нууцлалын бодлогыг <https://www.cardiovascular.abbott/int/en/policies/merlin-net.html> хаягаар авах боломжтой.

Монитор. Үйлчилгээний нэг хэсэг болгон Өгөгдөл дамжуулах болон/эсвэл Командуудыг дамжуулах/хүлээн авах, Клиник эсвэл Хэрэглэгчид Өвчтөний төхөөрөмжийг хянах болон/эсвэл удирдахад туслах зорилгоор ямар ч хэлбэрийн цахим төхөөрөмж эсвэл аппликэйшнууд. Мониторууд нь зөөврийн байж болох ба үүнд ухаалаг гар утас, таблет, ширээний дамжуулагч, бусад Өвчтөн эсхүл эмнэлгийн ажилтнуудын ашигладаг электрон төхөөрөмжүүд багтаж болно. Мониторууд нь Өвчтөний Гар утасны аппликэйшн суулгасан бусад техник хангамжийг агуулж болно. Мониторууд нь бид нийлүүлсэн болон/эсвэл ажиллуулсан байж болно эсвэл үгүй ч байж болно.

Өвчтөн. Үйлчилгээгээр дамжуулан Клиник эсвэл Хэрэглэгчийн хяналт тавих болон/эсвэл удирдаж буй Абботт төхөөрөмжтэй аливаа өвчтөн.

Өвчтөний гар утасны аппликэйшн. Бидний нийлүүлсэн болон Өвчтөн өөрийн Төхөөрөмжийг ашиглахтай холбогдуулан Монитор болгон ашигладаг гар утасны аппликэйшн.

Үйлчилгээ. Энэхүү Гэрээний дагуу www.merlin.net сайтад байрлах Merlin.net PCN эсвэл Абботтын зүгээс танд олгож болох, мөн Төхөөрөмжүүдийг дэмжихэд ашигладаг бусад ийм URL ("Merlin.net" эсвэл "Сайт")-тай холбоотой танд санал болгож буй онлайн болон бусад үйлчилгээ, техник хангамж; техникийн дэмжлэг, засвар үйлчилгээ; сургалт; Өвчтөний боловсрол, тусламж Merlin.net дээр алсын хяналтыг тохируулах, идэвхжүүлэх, мөн боломжтой тохиолдолд Төхөөрөмжийг Монитортой зайнаас, контактгүй хослуулах үйлчилгээ орно; Төхөөрөмжтэй холбоотой өгөгдлийг цуглуулж, хост хийх; тайлагнах; мөн хүсэлтийн дагуу Төхөөрөмжтэй холбоотой мэдээллийг тайлбарлах болон дүн шинжилгээ хийхэд тусламж үзүүлэх үйлчилгээ орно. Үйлчилгээнд таны зааварчилгаа, зөвшөөрлийн дагуу, мөн Өвчтөнийг бүртгүүлсний дараа Абботт таны өмнөөс Өвчтөнтэй шууд холбогдож, монитормын тохиргоо, түүний ажиллагаа болон/эсхүл Merlin.net-н холболт мөн шаардлагатай, боломжтой бол тусдаа Монитор тээвэрлэхтэй холбоотой онлайн болон/эсхүл утсаар дэмжлэг үзүүлж болно. Үйлчилгээ нь Абботтоос өвчтөн бүртгэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор таныг Merlin.net-д нэвтрэх тодорхой мэдээлэл өгөхийг хүсэх боломжтой. Өвчтөнд суулгасан Төхөөрөмжөөс хамааран Үйлчилгээ нь та Өвчтөний эмд өөрчлөлт хийсэн талаар хэлэх боломжийг олгох эсвэл эмчилгээний бусад өөрчлөлтийг хийх боломжийг олгож болно. Үйлчилгээнд Абботтоос Өвчтөнүүдэд эмнэлгийн зөвлөгөө эсвэл тусламж үзүүлэх ямар нэгэн үйлчилгээ хамаарахгүй. Үйлчилгээ нь зөвхөн биднээс эсвэл манай борлуулагчдаас авсан Абботт Төхөөрөмжүүдийн дэмжлэгт зориулагдсан болно.

Хэрэглэгч. Аливаа эмнэлгийн эсвэл эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч, эмч (болон тэдгээрийн зохих ёсоор итгэмжлэгдсэн төлөөлөгч, агентууд) эсвэл Клиниктэй холбоотой бусад хэрэглэгч Merlin.net-д нэвтрэх, ашиглах хэрэглэгчийн нууцлалыг тухайн клиникээс олгодог.

Бид, биднийг, манай болон/эсвэл Абботт. "Бид", "биднийг" болон "манай" гэж энэхүү Гэрээний 39 Хэсэгт заасан тухайн Абботт компанид хамаарах бөгөөд уг компани нь энэхүү Гэрээний хамтрагч тал юм. Тухайн Абботт компани нь Үйлчилгээг үзүүлэх болон гүйцэтгэхийн тулд Абботтын харьяа бусад компанийг ашиглаж болно. "Талууд" гэдэг нь та болон таны Байршилд хамаарах тухайн Абботт компанийг хэлнэ.

Та, таны, болон танай. Клиник, Администратор, эсвэл Хэрэглэгч.

3. Merlin.net-н Үйлчилгээний тодорхойлолт: Үйлчилгээ нь Өвчтөний өгөгдөл болон/эсвэл Төхөөрөмжүүдийн зарим асуудлыг хянах болон удирдах, мөн тохирох тохиолдолд Өгөгдлийг цахим эрүүл мэндийн бүртгэлийн систем рүү экспортлоход туслах зорилготой. Үйлчилгээ нь биднээс хангагдаагүй интернет, харилцаа холбооны систем, гуравдагч талын үйлчилгээ үзүүлэгч, платформ, программ хангамж болон Мониторын хандалт зэргээс шалтгаална. Бид гуравдагч талын гүйцэтгэл, хоцорсон гүйцэтгэл, алдаа, өгөгдлийн гэмтэл эсвэл алдагдал эсхүл гүйцэтгэлгүй байдалд хариуцлага хүлээхгүй. Үйлчилгээ нь Клиник өөрийн байршил дээрээс Өвчтөний Төхөөрөмжийн талаар тодорхой мэдээллийг алсаас цуглуулахыг зөвшөөрдөг бөгөөд санал болгож, батлагдсан тохиолдолд Хэрэглэгчид Өвчтөний Төхөөрөмжийг алсаас тохируулах боломжийг олгоно.

Үйлчилгээ нь Өвчтөнүүдийн шууд ашигладаг эрүүл мэндийн үйлчилгээ биш бөгөөд бид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эсвэл ханган нийлүүлэгч биш болно. ХЭРЭВ ӨВЧТӨНД ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ ХЭРЭГТЭЙ БОЛСОН ТОХИОЛДОЛД ТА ӨӨРИЙН ЭМНЭЛГИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАНДАХЫГ ЗААВАРЛАНА УУ. Манай техникийн тусламж үзүүлэх ажилтнууд Клиникийн Өвчтөнүүдэд Өвчтөнүүдээс эсвэл Төхөөрөмжөөс дамжуулсан Өгөгдлийн агуулга, утга, эсвэл боломжит үр дагаврын талаар мэдээлэл өгөх эрхгүй болно.

Үйлчилгээ нь зарим үед хязгаарлагдаж болох ба бид Үйлчилгээг тасралтгүй ашиглах боломжтой гэх баталгаа өгч чадахгүй. Үйлчилгээг зөв ажиллуулахын тулд олон төрлийн механик, цахилгаан, тооцоолол, дамжуулалт, харилцаа холбоо, хүний хүчин зүйл шаардагддаг бөгөөд тус бүр нь хязгаарлалт, алдаа, үе үе алдаа дутагдалтай байдаг. Тэдгээр олон хүчин зүйлс нь аль ч талын хяналтаас гадуур байна.

4. Үйлчилгээнд хандах: Манай Сайтын клиник хэсэгт хандах эрх нь зөвхөн Хэрэглэгчдэд зориулагдсан. Манай сайтын Хэрэглэгчдэд тэдний холбогдох Клиникээс давтагдаагүй Хэрэглэгчийн ID олгогддог бөгөөд хэрэглэгчид манай Сайтад нэвтрэхийн тулд өөрийн нууц үгээ сонгох ёстой. Хэрэглэгчид хувийн холбоо барих мэдээллийг өгөх шаардлагатай бөгөөд та өөрийн мэдээллийг тухай бүр шинэчилж байх ёстой. Хэрэглэгчийн ID болон нууц үг нь цахим гарын үсэг болж, манай Сайтад хандах эрхийг баталгаажуулахад ашиглагдана. Хэрэв Хэрэглэгч Merlin.net-д нэвтрэхээр сонгосон бол, Хэрэглэгч манай Сайтын нээлттэй бус хэсгүүдийг ашиглах боломжтой болно. Хэрэв Хэрэглэгч манай Сайтад нэвтрэхгүй гэж сонговол манай Сайтад хандах эрх нь зөвхөн Сайтын нээлттэй хэсгүүд болж хязгаарлагдах болно. Хэрэв танд Хэрэглэгчийн ID, нууц үг эсвэл манай аюулгүй байдлын журмын дагуу ямар нэгэн бусад мэдээллийг өгсөн бол энэ мэдээллийг нууц гэж үзэж, гуравдагч этгээдэд илчлэхгүй байх үүрэгтэй. Хэрэв бид таныг энэ Гэрээний аль нэг заалтыг биелүүлээгүй гэж үзвэл ямар ч үед аливаа Хэрэглэгчийн ID-г хаах эрхтэй. Та зөвхөн энэ Гэрээнд заасан журмын дагуу манай Сайтыг ашиглах боломжтой. Манай сайтыг хууль бус эсвэл зөвшөөрөлгүй ашиглах нь энэ Гэрээний зөрчилд тооцогдоно. Та энэхүү Гэрээг зөрчсөн эсвэл ямар нэгэн холбогдох хуулийг зөрчсөн аль ч тохиолдолд манай Сайтад хандах эрхгүй болно. Та өөрийн болон таны Өвчтөнүүдийн мэдээллийг үнэн зөв, сүүлийн үеийн байдлаар шинэчлэх, бүрэн бүтэн байлгахыг зөвшөөрч байна. Та Өвчтөний тусламж үйлчилгээнд ашиглах эсвэл зөвхөн Өвчтөний цахим эрүүл мэндийн бүртгэлд оруулах зорилгоор манай Сайтаас хуудас(ууд)-ыг хэвлэж авах эсвэл татаж авах боломжтой.

5. Агуулга: Манай сайт нь тодорхой Абботт Төхөөрөмжүүдийг онцгойлон ашиглах, дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэхүү Сайт болон үйлчилгээ нь таны Өвчтөнд үзүүлэх халамжийг сайжруулах зорилгоор хийгдсэн гэдгийг та хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд эдгээр нь таны мэргэжлийн дүгнэлт эсвэл Өвчтөний өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг тань орлохгүй гэдгийг та хүлээн зөвшөөрч байна. Хэрэв өөрөөр заагаагүй бол манай Сайт нь зөвхөн мэдээллийн зориулалттай. Merlin.net сайтад харагдах эрүүл мэндийн тусламжийн ажилтнуудаас олгосон эрүүл мэндийн мэдээллийн агуулга болон Өвчтөнүүдийн Төхөөрөмжтэй холбоотой өгөгдөл дамжуулалтад үндэслэсэн болно. Merlin.net дээр харагдах эрүүл мэндийн мэдээллийн агуулга нь Өвчтөнд зориулсан зөвлөгөө биш бөгөөд Өвчтөнд зориулсан зөвлөгөөний оронд хэрэглэгдэхгүй гэдгийг анхаарна уу. Merlin.net дээрх эрүүл мэндийн мэдээллийн аливаа агуулга цаг хугацааны хувьд хуучирсан байж болох бөгөөд эдгээр мэдээлэл нь Хэрэглэгчдийн болон таны Өвчтөнүүдийн Төхөөрөмжтэй холбоотой дамжуулсан өгөгдлөөс бүрдсэн байдаг тул бид ийм агуулгыг шинэчлэх үүрэг хүлээдэггүй.

БИДНИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БИШ, ӨВЧТӨНҮҮДЭД ЭМНЭЛГИЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХГҮЙ ГЭДГИЙГ ТА ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙНА. МАНАЙ САЙТ ДЭЭРХ ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА НЬ МЭРГЭЖЛИЙН ЭМНЭЛГИЙН ЗӨВЛӨГӨӨГ ОРЛОХ ЗОРИЛГОТой БИШ МӨН ҮҮНИЙГ САНАЛ БОЛГООГҮЙ БӨГӨӨД ЗӨВХӨН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ ӨГӨХ ЗОРИЛГОТой БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД БОЛОН ТЭДНИЙ ӨВЧТӨНҮҮДИЙН ХООРОНДОХ ХАРИЛЦААГ ОРЛОХ БУС ДЭМЖИХ ЗОРИУЛАЛТТАЙ ГЭДГИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙНА. БИД БОЛОН МАНАЙ УДИРДЛАГА, ЗАХИРАЛ, АЖИЛТАН, АГЕНТ, ТҮНШ БАЙГУУЛЛАГУУД БОЛОН ХОЛБОГДОХ КОМПАНИУД НЬ САЙТАД НИЙТЭЛСЭН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГЫГ ОРУУЛАХ БОЛОВЧ ҮҮГЭЭР ХЯЗГААРЛАГДАХГҮЙГЭЭР АГУУЛГЫН АЛДААТАЙ ЭСВЭЛ ХАСАГДСАН БАЙДАЛД ЯМАР Ч ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ, МӨН ТА ЭСВЭЛ ЯМАР НЭГЭН ХҮНД МАНАЙ САЙТЫН ЭДГЭЭР ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГЫГ ОРУУЛАХ

БОЛОВЧ ҮҮГЭЭР ХЯЗГААРЛАГДАХГҮЙГЭЭР АГУУЛГЫН ҮНЭН ЗӨВ, ИТГЭЛТЭЙ БАЙДАЛ ЭСВЭЛ АГУУЛГЫН ТАЛААР МЭДЭЭЛЭХ ГЭЖ БАЙГАА БОЛ МАНАЙ САЙТ ДЭЭРХ ИЙМ АГУУЛГАД НАЙДАХ ЁСТОЙ.

ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН ҮЗҮҮЛЖ БУЙ ӨГӨГДӨЛ БОЛОН БУСАД МЭДЭЭЛЭЛД ҮНДЭСЛЭН ХИЙСЭН КОМАНД, БОЛОН ТЭДГЭЭРТ НАЙДАЖ БУЙ БАЙДАЛ, ШИЙДВЭРҮҮДИЙН ХАРИУЦЛАГЫГ ТА ЗӨВХӨН ГАНЦААРАА ХҮЛЭЭНЭ. ЭДГЭЭР КОМАНД ЭСВЭЛ ТА ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ДАМЖУУЛАН ОЛЖ АВСАН МЭДЭЭЛЭЛД НАЙДСАНЫ ТӨЛӨӨ БИД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ. Манай ажилтнууд аливаа Өгөгдлийн шинж чанар, утга агуулга эсвэл боломжтой үр дагаврын тухай Өвчтөнүүдэд мэдээлэх эрхгүй.

6. Манай Сайт болон Үйлчилгээний хориотой хэрэглээ: Хэрэв бидний бодлоор та энэхүү Гэрээний өөрт хамаарах аливаа заалтыг дагаж мөрдөөгүй гэж үзвэл бид аливаа хэрэглэгчийн ID-г ямар ч үед идэвхгүй болгох эрхтэй. Манай Сайтыг ашиглахдаа та доорх хориглосон үйлдлүүдийг хийхгүй байх ёстой. Хуулиар заасан бол Өвчтөний мэдээлэлтэй, сайн дурын болон тодорхой зөвшөөрлийг авалгүйгээр Хэрэглэгч Merlin.net сайтад Өвчтөнийг бүртгүүлэх эсвэл өвчтөний профайл үүсгэх ёсгүй. Та Үйлчилгээ эсвэл Сайтыг АШИГЛАХГҮЙ гэдгээ хүлээн зөвшөөрч байна:

- (i) насанд хүрээгүй хүүхдийг оролцуулаад аливаа хүнд хор хөнөөл учруулах, гэмтээх оролдлого хийх эсвэл холбогдох хуульд заасан тохиолдолд эсвэл өөр зөвшөөрөлгүйгээр аливаа Өвчтөн эсвэл хүнээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр мэдээлэл цуглуулах, хадгалах, байршуулах;
- (ii) бид бичгээр ийм хүрээ, холбоосыг тодорхой зөвшөөрөөгүй л бол манай Сайтад зар сурталчилгаа эсвэл бусад хүсээгүй сурталчилгааны материалуудыг дамжуулах, хүрээ үүсгэж, холбоос байршуулах;
- (iii) Энэхүү Гэрээнд тусгайлан заасан эсвэл үйлчилгээгээ эрүүл мэндийн цахим бүртгэлийн системдээ нэгтгэхийн тулд биднээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд биднээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр уг Үйлчилгээнд хамаарах аливаа материал, баримт бичиг болон бусад мэдээллийг хуулбарлах, сэргээх, дахин хэвлэх, байршуулах, нийтлэх, дамжуулах, экспортлох, түгээх; холбогдох хуульд хориглосон хязгаарлалтаас бусад тохиолдолд;
- (iv) аливаа хууль, дүрэм, захирамж, журмыг хууль бусаар буюу бусад байдлаар зөрчсөн;
- (v) эрүүл мэндийн мэдээллийн агуулгыг ашиглах, дахин худалдах, дахин түгээх, цацах, дамжуулах эсвэл Өвчтөний цахим эмнэлгийн бүртгэлд өөрөөр зөвшөөрөгдөж эсвэл ашиглагдаагүй тохиолдолд манай Сайтаас олж авсан эрүүл мэндийн мэдээллийн агуулгыг хайх боломжтой, машинаар унших боломжтой мэдээллийн санд ашиглахыг оролдох;
- (vi) Merlin.net-ийн Нууцлалын Бодлогыг зөрчиж, эсвэл бусад байдлаар Хэрэглэгчид эсвэл Өвчтөнүүдийн хувийн мэдээллийг цуглуулах;
- (vii) Сайт эсвэл Үйлчилгээний хэвийн үйл ажиллагаанд хор хөнөөл учруулах, саад учруулах, хязгаарлах зорилготой вирус эсвэл бусад компьютерын код, файл, программ агуулсан аливаа материалыг байршуулах, нийтлэх, цахим шуудангаар илгээх, дамжуулах, хадгалах эсвэл бусад хэлбэрээр ашиглах боломжтой болгох, эсвэл аливаа систем, Өгөгдөл эсвэл хувийн мэдээллийг нууцаар таслан зогсоох, өмчлөх;
- (viii) Сайтын үйл ажиллагаанд оролцох буюу саад хийх (үүнд үнэтэй программууд эсвэл веб хавчигч зэрэг автоматжуулсан аргуудаар Сайт руу нэвтрэх), Үйлчилгээнд холбогдсон сервер эсвэл сүлжээнүүдтэй, эсвэл манай Сайтад холбогдсон сүлжээний аливаа бодлого, шаардлага, дүрэм журмуудыг зөрчих (ялангуяа тэдний өгөгдөл эсвэл хөдөлгөөн хянах болон хяналтын эрхтэй хандах эрх багтана) эсвэл өөр ямар нэгэн төхөөрөмж, программ хангамж эсвэл үйлдлээр манай Сайтын ажиллагаанд саад хийх эсвэл бусдыг манай Сайтыг ашиглахад саад хийх;
- (ix) үйлчилгээг эсвэл сайтын онцлог, гүйцэтгэлийн талаар ямар ч гуравдагч этгээдэд биднээс урьдчилсан зөвшөөрөл авалгүйгээр мэдээлэл задруулах, хуулийн эсвэл зохицуулалтын зорилгоор эсвэл Өвчтөний эмнэлгийн эмчилгээг дэмжих зорилгоор биш бол манай Сайтын ашиглалт нь бидэнд ямар нэгэн хохирол учруулж, нэр хүндийг нь муутгах эсвэл сөргөөр нөлөөлөх ямар нэгэн байдлаар ашиглахыг хориглоно;

- (x) Үйлчилгээг бүрдүүлдэг аливаа программ хангамж, техник хангамж, бүрэлдэхүүн хэсэг эсвэл бусад хэсгүүдээс үүсмэл бүтээл үүсгэх, бусад компьютерын систем, программуудтай нэгтгэх, урвуу инженерчлэл хийх, задлах, эвдэх;
- (xi) дээр дурдсан хориглосон үйл ажиллагаатай холбогдуулан Сайт эсвэл Үйлчилгээний бусад хүмүүс эсвэл Төхөөрөмжтэй аливаа Өвчтөний эрүүл мэндийн мэдээлэл зэрэг хувийн мэдээллийг цуглуулах, хадгалах, байршуулах, эсвэл
- (xii) аливаа хүний оюуны өмчийн эрхийг зөрчих (үүнд таны байршуулах эрхгүй аливаа агуулгыг байршуулах гэх мэт).

Хэрэв та энэхүү Гэрээг зөрчиж манай Сайтын аль нэг хэсгийг хэвлэх, хуулах, дахин нийтлэх, татаж авах тохиолдолд өөрийн хийсэн материалуудын зөвшөөрөлгүй хуулбарыг устгах ёстой.

7. Барааны тэмдэг: Merlin.net™ PCN болон холбогдох брэндүүд нь Абботт болон түүний холбогдох компаниудын төрөл бүрийн эрх мэдэл дэх барааны тэмдэг ба үйлчилгээний тэмдэг бөгөөд Үйлчилгээг ашиглах замаар Merlin.net™ PCN болон холбогдох брэндүүдийн барааны тэмдэг, үйлчилгээний тэмдгээс үүсэж болох аливаа сайн санааны байдал нь Abbott-ийн ашиг тусын тулд ашиглагдах бөгөөд шаардлагатай тохиолдолд Абботт-д хуваарилагдана. Бусад барааны тэмдэг нь тус тусын эздийнхээ өмч болно. Дээр дурдсан барааны тэмдгийн аль нэгэнд нь ямар ч тусгай зөвшөөрөл, эрх шууд болон далд хэлбэрээр танд олгогдоогүй болно. Та цаашид Merlin.net™ PCN эсвэл Үйлчилгээнд хавсаргасан эсвэл дотор нь агуулагдаж буй өмчийн мэдэгдлийг (барааны тэмдэг, зохиогчийн эрхийн мэдэгдлийг оруулаад) устгах, нуух, өөрчлөхгүй гэдгээ зөвшөөрч байна. Абботтын лого, үйлчилгээний тэмдэг, барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэр буюу бүтээгдэхүүний дүр төрхийг компанийн бүтээгдэхүүн, үйлчилгээг тодорхойлохоос бусад зорилгоор Абботтоос урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд ашиглахыг хориглоно.

8. Өмчлөх эрх: Та Абботт болон/эсвэл түүний лиценз эзэмшигчид Сайтыг гүйцэтгэхэд ашигласан дизайн, график, хэрэглэгчийн интерфэйс, хуудасны толгой хэсэг, зураг, дүрслэл, аудио клип, бичвэр, скрипт, мэдээллийн сангийн бүтэц, программ хангамж зэрэг орох боловч үүгээр хязгаарлагдахгүйгээр Merlin.net, Үйлчилгээ, Мониторууд болон тэдгээрт хамаарах бүх зохиогчийн эрх, патент, худалдааны нууц эрх, худалдааны тэмдэг болон бусад оюуны өмчийн эрхийг бүхий л хууль ёсны эрх, нэр, ашиг сонирхлыг эзэмшдэг гэдгийг та хүлээн зөвшөөрч, зөвшөөрч байгаа бөгөөд Үйлчилгээнүүдийн нэг хэсэг болон/эсвэл тэдгээртэй холбоотой танд олгосон аливаа программ хангамж, баримт бичиг, үүнд бүртгэлтэй, бүртгэлгүй, дэлхийн хаана ч байсан оюуны өмчийн бүх эрхийг багтаасан болно. Merlin.net, Үйлчилгээ болон Мониторууд нь оюуны өмчийн эрх болон бусад хуулиар хамгаалагдсан өмчийн болон нууц мэдээллийг агуулж байгаа бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй гэдгийг та мөн зөвшөөрч байна. Та энэхүү Гэрээний дагуу Merlin.net болон холбогдох Үйлчилгээг ашиглахаас бусад тохиолдолд эдгээр өмчийн мэдээлэл, материалыг ашиглахгүй гэдгээ хүлээн зөвшөөрч байна. Энэхүү Гэрээнд тодорхой зөвшөөрснөөс бусад тохиолдолд эсвэл холбогдох хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд Сайт эсвэл Үйлчилгээний аль ч хэсгийг ямар ч хэлбэрээр, ямар ч аргаар хуулбарлаж болохгүй. Та Merlin.net сайтаас ямар нэгэн бүтээгдэхүүн, Төхөөрөмжийн таних тэмдэг, зохиогчийн эрхийн мэдэгдэл, өмчийн хязгаарлалтуудыг устгах ёсгүй. Та Үйлчилгээ нь танд зарагдаагүй, харин зөвхөн лицензээр олгогдсон гэдгийг үргэлж хүлээн зөвшөөрөх бөгөөд Абботт, түүний лиценз эзэмшигчид, харьяа компаниуд, нийлүүлэгчид танд Merlin.net-ийг ашиглах эрхийг энэ Гэрээний дагуу олгох бөгөөд уг эрх нь онцгой бус, дамжуулах, шилжүүлэх боломжгүй ба таны Merlin.net-ийг ашиглахад Абботтын гуравдагч талын хангамжийн эрх зүйн дүрэм, бодлогууд мөрдөгдөх болно. Тиймээс та Абботт болон/эсвэл түүний лиценз эзэмшигчид ямар ч хэрэглэгчид merlin.net, оюуны өмчийн эрх, эсвэл бусад технологи, мэдээлэл, материалыг өмчлөх эрх, эзэмших эрхийг шилжүүлэхгүй гэдгийг зөвшөөрөх бөгөөд Талуудын хооронд, Абботт, түүний харьяа компаниуд, нийлүүлэгчид болон лиценз эзэмшигчид merlin.net-ийн бүхий л талбарт оюуны өмчийн бүх эрх, бусад бүх технологи, мэдээлэл, материал, түүнчлэн тэдгээрийн аливаа хуулбар эсвэл өөрчлөлтийг (хэн ч, хэзээ ч хийсэн бай) онцгой өмчлөх эрхээ хадгална. ЭНД ТОДОРХОЙ ЗААГААГҮЙ БҮХ ЭРХИЙГ АББОТТ БОЛОН/ЭСВЭЛ ТҮҮНИЙ ЛИЦЕНЗ ЭЗЭМШИГЧИД ХАДГАЛНА. Зарим улс/муж/дүүрэг/харьяалалд дээр дурдсан зүйл үр дүнгүй болохоос бусад тохиолдолд энэ материалыг ашиглах болон Абботт, түүний харьяа компаниуд, нийлүүлэгчдийн холбогдох эрхийг үүгээр хүлээн зөвшөөрч байна.

9. Санал хүсэлт: Таны нийлүүлсэн аль ч өгөгдөл, сэтгэгдэл эсвэл материалуудыг эсвэл та ямар нэгэн санаа, мэдээлэл, ойлголт, ноу-хау, арга техник эсвэл материалуудыг бидэнд илгээх, эсвэл дэмжлэг авах, Үйлчилгээ, Монитор эсвэл Үйлчилгээг бүрдүүлдэг аливаа программ хангамж, тоног төхөөрөмж, бүрэлдэхүүн хэсэг эсвэл бусад хэсгийг сайжруулах, өөрчлөх зорилгоор Абботтод өгсөн бол асуулт, сэтгэгдэл, саналууд зэрэг санал хүсэлтийн өгөгдөл ("**Санал хүсэлт**") нь нууцлалгүй, өмчийн эрхгүй гэж тооцогдох болно. Абботт нь ийм Санал хүсэлттэй холбоотой ямар ч үүрэг хариуцлага хүлээхгүй бөгөөд Санал хүсэлтийг (санал хүсэлтэд тусгагдсан байж болох боловч доорх "Лиценз" гэсэн хэсэгт хамаарах өгөгдөл болон хувийн мэдээллээс бусад) манай сайтаар эсвэл өөр хэлбэрээр хуулбарлах, ашиглах, задруулах, үзүүлэх, харуулах, шилжүүлэх, үүсмэл бүтээл туурвих болон түгээхийг түгээх чөлөөтэй байх ба таны Санал хүсэлт Абботтын онцгой өмч болох бөгөөд Абботт танд ямар ч нөхөн төлбөр өгөхгүйгээр ашиглах боломжтой. Түүнээс гадна Абботт нь ийм Санал хүсэлтэд агуулагдсан аливаа санаа, үзэл баримтлал, ноу-хау эсхүл арга техникийг ямар ч зорилгоор ашиглах ба тухайлбал ийм Санал хүсэлтийг агуулсан бүтээгдэхүүнүүдийг боловсруулах, үйлдвэрлэх, борлуулах зэрэгт чөлөөтэй ашиглах боломжтой.

10. Лиценз: Абботт нь таны Сайт эсвэл Үйлчилгээгээр дамжуулж, илгээсэн хувийн мэдээллийг өмчлөх эрхийг эзэмшдэггүй. Та өөрийн хувийн мэдээллийг Абботтод задруулснаар Абботт ийм Үйлчилгээг үзүүлэх үүрэг хүлээсэн хугацаанд танд үйлчилгээ үзүүлэх зорилгоор ийм өгөгдлийг ашиглах, түгээх, үйлдвэрлэх, өөрчлөх, дасан зохицох, хэвлэн нийтлэх, орчуулах дэлхий даяар шимтгэл төлөхгүй, шилжүүлэх боломжтой, онцгой бус, дэд лицензтэй, бүрэн төлбөртэй лиценз олгоно. Абботт нь судалгааны зорилгоор Үйлчилгээнээс олж авсан мэдээллийг нэгтгэсэн, нэрээ нууцалсан, танигдахгүй (эсвэл танай хуулиар зөвшөөрөгдсөн хэмжээгээр хуурамч нэрээр нэрлэсэн) өгөгдлийг үүсгэх, хандах, хадгалах, ашиглах, гуравдагч этгээдийн судлаачдад задруулах, Үйлчилгээг хэрхэн үзүүлж байгааг үнэлэх, түүний хэрэглээ болон түүний төрөл бүрийн бүрэлдэхүүн хэсэг, тоног төхөөрөмжийг үнэлэх, клиникийн ажилтнууд эсвэл эмнэлгүүдэд үзүүлэх гүйцэтгэл, нөлөөллийг үнэлэх, Сайт болон Төхөөрөмжийн ажиллагааг сайжруулах, Сайт эсвэл Мониторын шинэчлэлтүүдийг эсвэл бүтээгдэхүүний хөгжил, эмнэлгийн хэрэгслүүдийн чанар, аюулгүй байдлыг баталгаажуулах. Та энэхүү лиценз нь Абботтод дараах үйлдлүүдийг хийх эрх олгохыг зөвшөөрч байна. Хувийн мэдээллийг Үйлчилгээ үзүүлэхэд туслах зорилгоор гуравдагч этгээдийн ханган нийлүүлэгчдэд өгсөн тохиолдолд, тэд хувийн мэдээллийг нууцлалтай, аюулгүй байлгах үүрэгтэй бөгөөд зөвхөн зайлшгүй шаардлагатай хэмжээнд хувийн мэдээллийг ашиглаж болно.

11. Абботтоос Үзүүлэх Үйлчилгээ: Бид уг Гэрээнд заасан Үйлчилгээг үзүүлэх болно. Үйлчилгээ дараах тохиолдолд ашиглах боломжгүй байж болно: (а) төлөвлөсөн болон төлөвлөөгүй түр зогсолт, засвар үйлчилгээ, өөрчлөлт эсвэл түр зогсоох үед, (б) цахилгаан эрчим хүчний тасалдал (ачаалал бууруулахыг оролцуулан) болон харилцаа холбооны тасалдал, эсвэл (в) бидний хяналтаас хэтэрсэн нөхцөл байдлаас үүдэлтэй, үүнд хязгаарлалтгүйгээр, хуулиар зөвшөөрөгдсөн тохиолдолд, байгалийн гамшиг, засгийн газрын үйлдэл, үер, гал түймэр, газар хөдлөлт, иргэний үймээн, террорист үйлдэл, ажил хаялт эсвэл бусад хөдөлмөрийн асуудал (манай ажилтнуудтай холбоотойгоос бусад), интернет үйлчилгээ үзүүлэгчийн алдаа эсвэл Өвчтөн Үйлчилгээтэй холбогдуулан ашигладаг гуравдагч этгээдийн Мониторын саатал, гуравдагч этгээдийн платформ, үйлчилгээ эсвэл программ хангамж эсвэл аппликэйшн эсвэл үйлчилгээний довтолгоог үгүйсгэх зэрэг орох боловч үүгээр хязгаарлагдахгүй.

Абботтын орон нутгийн үйлчилгээний төлөөлөгч эсвэл нийлүүлэгчээс Клиникт үйлчилгээний дэмжлэг болон сургалтыг үзүүлэх болно. Бид нэмэлтээр онлайн эсвэл утсаар уг Үйлчилгээний талаар сургалт, дэмжлэг тусалцаа үзүүлж болох ба техникийн тусламжийг Абботтын харьяа компаниас үзүүлж болно.

Үйлчилгээ нь тодорхой хугацааны дараа онцлогууд нэмэгдэх, өөрчлөгдөхөөс хамаарч шинэчлэгдэнэ. Бид тухай бүрд, өөрийн үзэмжээр тодорхой функц нэмэх, өөрчлөх, хасах, мөн бусад тохиолдолд Үйлчилгээг сайжруулах эрхтэй. Үйлчилгээний талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг www.merlin.net хаягаар хандаж авах эсвэл танай Клиникийн хэрэглэгчийн бүртгэл хариуцдаг үйлчилгээний төлөөлөгч эсвэл борлуулагчид хандана уу. Бид танд материалын өөрчлөлтүүдийн талаар урьдчилан мэдэгдэхийн тулд арилжааны үндэслэлтэй хүчин чармайлт гаргаж, холбогдох хуульд заасан тохиолдолд эдгээр өөрчлөлтийг зөвшөөрөхийг танаас хүсэх болно. Тодорхой хугацааны давтамжтайгаар уг Үйлчилгээний шинэчлэлт эсвэл яаралтай шинэчлэлтүүдийг нэвтрүүлэх бөгөөд бид тухайн үед танд

Үйлчилгээ үзүүлэх боломжгүй байж болно. Бид боломжтой тохиолдолд Үйлчилгээ тасалдах талаар танд урьдчилан мэдээлэх болно.

Бид Үйлчилгээгээр дамжуулсан Өгөгдөл болон Командуудыг үнэн зөв хадгалагдаж, вирус болон бусад гэмтэлгүйгээр танд хүртээмжтэй байлгахын тулд арилжааны хувьд үндэслэлтэй хүчин чармайлт гаргах болно.

Та биднийг аливаа Өгөгдөл эсвэл Командуудын хэлбэр, хүртээмж, үнэн зөв байдал, цаг хугацааны хувьд боломжтой байдал, агуулгын талаар, худалдааны хувьд үндэслэлтэй хүчин чармайлтаас гадуур ямар нэгэн хариуцлага хүлээхгүй гэдгийг зөвшөөрч байна.

Бид шинэ эсвэл сэргээн засварласан Мониторуудыг нийлүүлж болох бөгөөд хууль буюу эрх зүйн актаар ногдуулсан бүх баталгаа, нөхцөл болон бусад болзлыг хуулиар зөвшөөрсөн дээд хэмжээнд, энэхүү Гэрээнээс хасна.

Бид интернет зэрэг харилцаа холбооны сүлжээ болон байгууламжуудаар Өгөгдөл болон Командуудыг дамжуулах явцад үүссэн аливаа саатал, хүргэлтийн алдаа эсвэл бусад алдагдал, гэмтлийн төлөө хариуцлага хүлээхгүй бөгөөд та Үйлчилгээ нь ийм харилцаа холбооны байгууламжуудыг ашиглахад үйлчлэх хязгаарлалт, саатал болон бусад асуудалд өртөж болзошгүйг хүлээн зөвшөөрч байна.

Клиникийг Төхөөрөмж болон Өгөгдлийг хянах зорилгоор Merlin.net сайтаар хангахын зэрэгцээ Абботт Клиниктэй байгуулсан гэрээний дагуу Клиникт техникийн болон эмнэлзүйн дэмжлэг үзүүлэх болно. Клиник эсвэл Хэрэглэгч нь Абботтын ажилтнуудад Үйлчилгээг хүлээн авахад шаардлагатай тохиолдолд Өгөгдөлд хандах эрх олгож болох бөгөөд үүнд алдааг засах, Үйлчилгээг сайжруулах эсвэл алдааг олж засварлах, эсвэл Төхөөрөмжөөс дамжуулсан Өгөгдлийг тайлбарлах зэрэг техникийн болон эмнэлзүйн дэмжлэг авах зэрэг орно. Абботт Клиникийн өмнөөс эсвэл Клиникийн хүсэлтээр энэхүү боловсруулалтыг хийх үед Абботт үүнийг боловсруулагч/операторын хувьд гүйцэтгэдэг.

12. Клиникийн үүрэг: Үйлчилгээг авахын тулд Клиник дараахыг хүлээн зөвшөөрч байна:

- (i) Клиник нь өөрийн ажилтнууд, төлөөлөгчид, гэрээт ажилтнууд, агентууд болон Клиникт байгаа бусад хүмүүс, мөн Клиникийн байршилд Үйлчилгээг ашиглах эрх олгосон Хэрэглэгчдийг зохих ёсоор ашиглах, аюулгүй байдлыг хангахын тулд хянах, ажиглах, сургах үүрэгтэй. Клиник нь өөрийн байршилд Үйлчилгээнд хандах эрхийг зохих ёсоор зөвшөөрөгдсөн Хэрэглэгчдээр хязгаарлана. Клиник өөрийн Хэрэглэгчдийн (а) Үйлчилгээг ашиглах, (б) Энэ Гэрээнд заасан шаардлагыг дагаж мөрдөх, (в) Хэрэглэгчдийн үйлдлээс болж эсвэл Клиникийн байршилд гарсан аюулгүй байдлын аливаа зөрчилдөөний үр дагаврыг хариуцах болно.
- (ii) Энэ нь Үйлчилгээний журам, заавар, шинэчлэлт, өөрчлөлт хийгдсэн тухай бүрд дагаж мөрдөнө;
- (iii) Энэ нь Үйлчилгээний бүх Хэрэглэгчид энэ Гэрээ, хэрэглэгчийн гарын авлага, шинэчлэлтүүд болон хамаарах хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг хангах бөгөөд Клиникүүд ямар ч эрх зүйн шаардлагыг зөрчсөн тохиолдолд бүрэн хариуцлага хүлээх болно;
- (iv) Энэ болон түүний Хэрэглэгчид үйлчилгээнд ажиглагдаж буй аливаа согог, асуудлыг бидэнд нэн даруй мэдэгдэх бөгөөд эдгээр асуудлыг шийдвэрлэхэд бидэнтэй бүрэн хамтран ажиллах болно;
- (v) Та Үйлчилгээтэй холбоотой аливаа аюулгүй байдлын зөрчил гарсан тохиолдолд cybersecurity@abbott.com хаяг руу, эсвэл хувийн мэдээллийн зөрчил илэрсэн тохиолдолд cnprivacy@abbott.com хаяг руу нэн даруй мэдээлэх бөгөөд ажигласан эсвэл үндэслэлтэйгээр сэжиглэсэн зөрчлийн талаар бидэнтэй, хууль сахиулах байгууллага болон бусад холбогдох зохицуулалтын байгууллагатай бүрэн хамтран ажиллах үүрэгтэй;
- (vi) бидний үндэслэлтэй мэдэгдлийн дагуу энэ нь ердийн ажлын цагаар техникийн үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх, бусад үед чухал үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зорилгоор байршлаа бидэнд нээлттэй болгоно;

- (vii) Клиник нь Үйлчилгээ Клиникийн Өвчтөнүүдэд үзүүлэх тусламжийг сайжруулахад чиглэгдсэн болохыг хүлээн зөвшөөрч байгаа боловч Үйлчилгээ нь таны мэргэжлийн үзэл бодол эсвэл Өвчтөнүүдийн өмнө хүлээх үүргийг орлохгүй гэдгийг та ойлгож байна;
- (viii) Клиник уг үйлчилгээг ашиглах үедээ Өвчтөндөө эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, Өгөгдөлд цаг тухайд нь дүн шинжилгээ хийж, Өвчтөнд зохих эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд Өвчтөнд хяналт тавих хуваарь гаргах зэрэг хариуцлагыг хүлээх болно; бөгөөд
- (ix) энэ нь Хэрэглэгчдэд үйлчилгээ авахад шаардлагатай интернет холболт, цахилгаан хангамж, тооцоолох тоног төхөөрөмж, хангамж, гуравдагч талын программ хангамж, боловсон хүчнийг олж авах, хадгалах үүрэгтэй. Үйлчилгээний бүрэн ажиллагааг идэвхжүүлэхийн тулд Үйлчилгээ нь хамааралгүй гуравдагч этгээдийн (жишээ нь, веб хөтөч болон Adobe PDF үзүүлэгч) ("**Гуравдагч талын программ хангамж**") олгосон программ хангамжийг ашиглахыг шаардаж болно. Гуравдагч этгээдийн программ хангамжийг Клиник ашиглах нь уг Гуравдагч этгээдийн программ хангамжийг нийлүүлэгчдийн тогтоосон холбогдох нөхцөл, болзлуудад харьяалагдах бөгөөд Клиник нь эдгээр нөхцөл, болзлуудыг дагаж мөрдөх бөгөөд хэрэв боломжтой бол ийм Гуравдагч этгээдийн программ хангамжийг ашигласны төлбөрийг төлөх ёстой. Бид Гуравдагч этгээдийн программ хангамжийг ашиглахтай холбоотой бүх хариуцлага, баталгаа болон өр төлбөрөөс татгалзаж байна.

Үйлчилгээгээр дамжуулан Клиникт байгаа өгөгдөл нь цахим эмнэлгийн бүртгэл биш эсвэл үүнд зориулагдаагүй болно. Клиник нь өөрийн үзэмжээр Клиникийн байршилд Өвчтөний эмнэлгийн бүртгэлд оруулах шаардлагатай гэж үзсэн аливаа Өгөгдлийг татаж авах ба/эсвэл хэвлэх ёстой.

Клиникт администраторын ID-г олгоно. Администраторын ID, хэрэглэгчийн ID болон нууц үг нь цахим гарын үсэгтэй тэнцэх бөгөөд энэ нь үйлчилгээнд нэвтрэх, ашиглахыг баталгаажуулахад ашиглана. Клиник нь Клиникийн байршлуудын Администратор ID, Хэрэглэгчийн ID болон нууц үгсийг нууцлалтай гэж үзэж, Хэрэглэгч бүрд давтагдахгүй байх ёстойг баталгаажуулах үүрэгтэй. Клиник нь бүх ID болон нууц үгсийг ямар нэгэн шалтгаанаар зөвшөөрөлгүй хүмүүст задруулахгүй байхыг баталгаажуулах үүрэгтэй бөгөөд та ID болон нууц үгсийг ашиглан хийгдсэн бүх үйлдлийн төлөө хариуцлага хүлээнэ. Клиник нь бид Клиникийн Хэрэглэгчдийн дотоод удирдлага эсвэл захиргааны төлөө хариуцлага хүлээхгүй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Бид Клиникийн ID болон нууц үгсийг зохих ёсоор ашиглаж, Үйлчилгээнд хандах эрхийг шалгах, мөн Өгөгдөлд оруулсан аливаа өөрчлөлтийг илрүүлэхийн тулд шалгаж болно. Хэрэв ID эсвэл нууц үг алдагдсан гэж үзэх үндэслэл байгаа бол Клиник нөлөөлөлд өртсөн нууц үгийг өөрчлөх, хэрэглэгчийн ID-г устгах, эсвэл Клиникийн үйлчилгээг ашиглахыг хамгаалахад шаардлагатай бусад арга хэмжээг авах, тухайлбал нууц үгээ солих шаардлагатайг бидэнд мэдэгдэх зэргээр шаардлагатай бүх арга хэмжээг авна. Бид Клиникийн хүсэлтээр ID болон нууц үгсээ өөрчлөх бөгөөд аюулгүй байдлын зөрчилд сэжиглэгдсэн эсвэл заналхийлсэн тохиолдолд хүссэн үедээ өөрчлөх үүнийг эрхтэй.

Клиник нь Хэрэглэгчийн ID-р хангагдсан, Өгөгдөл боловсруулах эрх бүхий бүх хүмүүсийг гэрээгээр эсвэл нууцлалын зохих хууль дүрмийн ("**Өгөгдлийн Нууцлал**") дагуу нууц хадгалах үүрэг хүлээлгэх үйл ажиллагааг хариуцна. Бүх Хэрэглэгч Өгөгдлийн Нууцлалын энэхүү үүргийг дагаж мөрдөхийг зөвшөөрч байна.

Энэ Гэрээний дагуух аюулгүй байдлын аль нэг шаардлагыг Клиник эсвэл Хэрэглэгч зөрчсөн тохиолдолд үүнийг Гэрээний зөрчил гэж үзэж болох бөгөөд Клиник эсвэл Хэрэглэгчийн Үйлчилгээнд нэвтрэх эрхийг нэн даруй хасахад хүргэж болзошгүй. Хоёр тал аюулгүй байдлын зөрчлүүдийг нөгөөдөө нэн даруй шуурхай мэдэгдэх бөгөөд ингэснээр зохих арга хэмжээ авах боломжтой болно.

Та хууль эрх зүй, зохицуулалт, магадлан итгэмжлэлийн зорилгоор эсвэл Өвчтөнийг эмчлэхэд туслахаас бусад тохиолдолд Үйлчилгээний онцлог, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг биднээс урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.

13. Харилцан хүлээх үүрэг: Хоёр тал уг Үйлчилгээтэй холбоотой аливаа асуудал, алдааг шийдвэрлэхийн тулд хамтран ажиллана. Хоёр тал Үйлчилгээг ашиглахад хамаарах бүхий л хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөхийг зөвшөөрч байна.

14. Нууцлал: Хоёр тал болон талууд хоорондын нууцлал эсвэл өмчийн мэдээллийг, өөрийнхөө мэт хамгаалж, арилжааны хувьд үндэслэлтэй арга хэмжээ авч хамгаална. Талуудын аль нэг нь нөгөө талын нууцлал эсвэл өмчийн мэдээллийг зөвхөн энэ Гэрээнд зөвшөөрсөн хэмжээнд болон Үйлчилгээтэй холбогдуулан ашиглах болно. Энэ гэрээг зөрчөөгүй нөхцөлд мэдээлэл олон нийтэд ил болсон бол тухайн мэдээллийг цаашид нууц гэж үзэхгүй бөгөөд хэдийн ил болсон эсвэл энэ Гэрээнээс ангид хүлээн авсан талын дангаар бүтээсэн, эсхүл тухайн мэдээллийг задруулах эрх бүхий гуравдагч талаас зүй ёсоор олж авсан гэж үзнэ.

15. Абботт агуулга болон өгөгдлийг ашиглах: Та Абботт нь эмнэлгийн төхөөрөмж үйлдвэрлэгчийн хувьд чанар, аюулгүй байдал, зах зээлийн дараах сонор сэрэмжтэй холбоотой хууль тогтоомжийн шаардлагуудыг дагаж мөрддөг бөгөөд эдгээр хууль тогтоомжийн үүргүүдийн дагуу Абботт нь Merlin.net сайтад агуулагдах Үйлчилгээтэй холбоотой эсвэл Монитор, Төхөөрөмжүүдтэй холбоотой өгөгдлийг дараах зорилгоор ашиглах шаардлагатай болж болзошгүйг хүлээн зөвшөөрч байна:

- (i) Эмнэлгийн тоног төхөөрөмж, системийн чанар, аюулгүй байдал, үр ашгийг сайжруулах, мөн зүрх судасны эмгэгийг анагаах шинэлэг, үр дүнтэй эмчилгээг хөгжүүлэх;
- (ii) Үйлчилгээний аюулгүй байдал, хамгаалалтыг сайжруулах, хянах зэрэг Merlin.net Үйлчилгээний үйл ажиллагаа, шинэчлэлүүдийг бататгах;
- (iii) шаардлагатай бол хууль ёсны нэхэмжлэл гаргах, хэрэгжүүлэх, хамгаалах, эсхүл холбогдох хуульд заасан бусад тохиолдолд; болон
- (iv) Үйлчилгээ эсвэл Төхөөрөмжүүд нь эрүүл мэндийн нөхөн төлбөр авахад хүртээмжтэй эсвэл нийгмийн даатгал, даатгал эсвэл төсвийн санхүүжилтийн эрхтэй тохиолдолд.

Үүнээс гадна Абботт Үйлчилгээнүүдийн Өгөгдлийг судалгаа хийх, шинэ болон одоо байгаа онцлог, функцийг багтаасан эмнэлгийн төхөөрөмжүүдийг хөгжүүлэх, турших, Merlin.net Үйлчилгээнүүд, Мониторууд болон Абботт төхөөрөмжүүдийг бүтээгдэхүүн хөгжүүлэх, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, статистик болон судалгааны зорилгоор турших, сайжруулах зорилгоор ашиглахыг эрэлхийлж болох бөгөөд үүнийг хийхийг хүссэн тохиолдолд хуулийн дагуу шаардлагатай тохиолдолд таны эсвэл таны Өвчтөний зөвшөөрлийг авна.

16. Абботт Өвчтөн болон Хэрэглэгчийн хувийн өгөгдлийг боловсруулах

- (i) Үйлчилгээг үзүүлэх үед Абботт нь Клиникийн өмнөөс Өвчтөн болон Хэрэглэгчдийн хувийн мэдээллийг боловсруулах болно. Абботтын хувийн мэдээллийг боловсруулах талаарх тайлбарыг энэ Гэрээний Хавсралт I-т тусгасан болно.
- (ii) Зүйлийн 13-аалтыг үл харгалзан, Клиник болон Абботт хоёр нь тус тусын боловсруулалтад хамаарах холбогдох Өгөгдлийг хамгаалах хууль тогтоомжийг дагаж мөрдөхөөр тохиролцсон болно.
- (iii) Абботт дараахыг хийх болно:
 - (A) холбогдох хуульд өөрөөр заагаагүй эсвэл зөвшөөрөөгүй бол зөвхөн тус Гэрээнд заасан Клиникийн бичгээр өгсөн зааврын дагуу Клиникийн өмнөөс Өвчтөний болон Хэрэглэгчдийн хувийн мэдээллийг боловсруулах бөгөөд Үйлчилгээг үзүүлэхэд ашиглах болно. Клиник нь Абботтод өгсөн зааврууд нь холбогдох бүс нутгийн хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах хариуцлагыг дангаар хүлээнэ;
 - (B) 18-р хэсэгт харшлахгүйгээр Өвчтөний болон Хэрэглэгчдийн хувийн мэдээллийг хамгаалах техник, зохион байгуулалтын зохих арга хэмжээг хэрэгжүүлэх, ингэхдээ технологийн дэвшил, хэрэгжүүлэх өртөг, эрсдэлд тохирсон боловсруулалтын шинж чанар, хамрах хүрээ, нөхцөл байдал, зорилгыг харгалзах бөгөөд үүнд энэхүү Гэрээний Хавсралт II-т заасан арга хэмжээ багтана;

- (C) Клиникийн хүсэлтээр Абботт үзүүлэх Үйлчилгээний хугацаа дууссан буюу дуусгавар болсноос хойш 30 хоногийн дотор Клиникийн сонголтоор Абботт хуулийн дагуу хувийн мэдээллийг сэргээх шаардлагагүй, эсхүл зөвшөөрөөгүй л бол энэхүү Гэрээний дагуу Клиникийн нэрийн өмнөөс Абботт боловсруулсан Хэрэглэгчид болон Өвчтөнүүдийн бүх хувийн мэдээллийг яаралтай устгах буюу клиникт буцаах;
- (iv) Талууд холбогдох Өгөгдөл хамгаалах хуулиудад шаардагдах хэмжээнд Хэрэглэгчид болон Өвчтөний хувийн мэдээлэлд нөлөөлж буй Үйлчилгээтэй холбоотой аюулгүй байдлын аливаа үйл явдлын талаар тус зөрчлийг мэдсэнийхээ дараа хойшлуулалгүйгээр нөгөө талдаа мэдэгдэхийг зөвшөөрч, шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлын тус үйл явдлын болзошгүй сөрөг үр дагаврыг бууруулах арга хэмжээ авахыг зөвшөөрнө.
- (v) Абботт гуравдагч орнуудын хууль тогтоомжид захирагддаг бөгөөд энэ нь Абботт Хэрэглэгчид болон Өвчтөнүүдийн хувийн мэдээллийг боловсруулахыг шаардах боломжтой гэдгийг Клиник хүлээн зөвшөөрч байна. Тус гуравдагч орон дахь хууль нь Абботтын холбогдох Өгөгдөл Хамгаалах Хуулийг дагаж мөрдөж ажиллах чадварт нөлөөлөхгүй гэдгийг хамгийн сайн итгэлтэйгээр баталж байна.

